

Академич Б.Ринчений захидал харилцааны түүхээс

Жамбаагийн УУГАНБААТАР*

*Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Утга зохиол судлалын салбар*

From the History of the Correspondence of Academician B. Rinchen

UUGANBAATAR Jambaa

*Department of Literary Studies, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia*

Received: 25 September 2025 / **Accepted:** 01 October 2025 / **Published:** 30 December 2025

Монголын Үндэсний төв архивын “Академич Бямбын Ринчений хувийн хөмрөгийн байнга хадгалагдах баримтын данс”-д¹ намтар, эрдэм шинжилгээний ажил, уран зохиол, орчуулгын бүтээл зэрэгт холбогдох материалаас гадна гадаад, дотоодын эрдэмтэн судлаач, төр засгийн төлөөлөл, ард иргэдтэй харилцаж байсан олон тооны захидал хадгалагдаж байна.

Академич Б.Ринчений 1905-1977 онд хамаарах хувийн гаралтай баримтат өв 19 хайрцаг болон хавтас, задгай материалыг зээ хүү Ж.Хасболд нь 2014 оны 11 сарын 27-ны өдөр Монголын Үндэсний Төв Архивд жагсаалтаар хүлээлгэн өгсөн байна.

Баримтат өвийг эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлаар² 175 хадгаламжийн нэгж бүхий

Зураг 1. Академич Б.Ринчен (1905-1977)

“Академич Бямбын Ринчений хувийн хөрөнгийн байнга хадгалах баримтын данс” үүсгэн бүртгэжээ.

Дээрх баримтыг нарийвчлан үзвэл, академич Бямбын Ринчений бусад хүмүүст илгээсэн болон бусдаас хүлээн авсан захидлууд, зохиол орчуулгын эх бичмэлүүд, англи, франц, орос



* © Ж. Ууганбаатар, 2025, Email: uuganbaatarj@mas.ac.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

¹ Үндэсний төв архив. Б.Ринчений хувийн хөмрөгийн байнга хадгалагдах баримтын данс. Х №32, Д № 1, 2

² 2015 оны 05 сарын 01-ээс 06 сарын 15-ны өдрийг хүртэл эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг ахлах архивч Ж.Баасансүрэн, Ө.Оюун-Эрдэнэ хийж гүйцэтгэжээ.

хэлээрх өгүүллэгүүд, түүхийн холбогдолтой фото зургууд, хурал зөвлөгөөнд хэлсэн үгүүд, шүүмж саналууд, экспедицийн тэмдэглэлүүд, монгол хэл зүйн дэвтрүүд, тэмдэглэлийн дэвтрүүд, хэл судлалын тэмдэглэлийн дэвтрүүд, зохиолын нооргууд, эрдэм шинжилгээний тэмдэглэлүүд, данжуурын тэмдэглэлүүд зэрэг баримт байна.

Янз бүрийн өнгө, хэмжээтэй цаасан дээр харандаа, бал, бэхээр үйлдсэн гар бичмэл, машиндсан, хэвлэсэн эх баримтуудыг хувийн гаралтай баримт бичигтэй ажиллах арга зүйн дагуу агуулга, сэдэв, нэр төрөл, он цагаар нь ангилан төрөлжүүлж хадгаламжийн нэгж бүрдүүлжээ. Баримтын агуулга, ач холбогдлыг харгалзан үзэж, хувийн гаралтай баримт бичигтэй ажиллах арга зүйн дагуу нэр төрөл, он цаг, агуулга сэдвээр нь ангилан төрөлжүүлж, хадгаламжийн нэгж бүрдүүлжээ. Үүнд:

1. Түүх намтрын холбогдолтой баримт
2. Зохиол бүтээл
 - 2.1 Кино зохиол
 - 2.2 Роман
 - 2.3 Найраглал
 - 2.4 Тууль
 - 2.5 Өгүүллэг
 - 2.6 Шүлэг
 - 2.7 Ерөөл магтаал
 - 2.8 Хэвлэлд өгсөн нийтлэл
 - 2.9 Зохиолын тайлбар зүүлт
3. Орчуулгын зохиол
 - 3.1 Жүжиг
 - 3.2 Түүхэн зохиол
 - 3.3 Орчуулга зохиол
 - 3.4 Өгүүллэг
 - 3.5 Шүлэг
 - 3.6 Үлгэр
4. Хэл шинжлэл
5. Эрдэм шинжилгээний бүтээл
 - 5.1 Түүх соёлын холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээл
 - 5.2 Овог ястан
 - 5.3 Эрдэм шинжилгээний өгүүлэл
 - 5.4 Шашин судлал
 - 5.5 Монгол ёс заншил
 - 5.6 Үлгэр домог
6. Шүүмж санал, илтгэл
7. Экспедицийн тэмдэглэл
8. Өдрийн тэмдэглэл
9. Захидал харилцаа
10. Цуглуулгын баримт

“Түүх намтрын холбогдолтой баримт” хэсэгт Зохиолчдын эвлэлийн жинхэнэ орлогч гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл, танилцуулга, шагналд дэвшүүлсэн тодорхойлолт, уран бүтээлийн тайлан, тодорхойлолт, хэлсэн үг, дурсамж дуртгал, хувийн фото зураг зэрэг баримт, “Зохиол бүтээл” хэсэгт өөрийнх нь зохиосон зохиол бүтээлүүдийн гар ноорог, эх бичмэлийг дэд бүлгүүдэд ангилан төрөлжүүлж, “Орчуулгын зохиол” хэсэгт орос, польш, франц, англи хэлнээс орчуулсан зохиолууд болон мөн гадаад хэлээрээ байгаа зохиолууд байна.

“Хэл шинжлэл” хэсэгт “Монгол хэлний зүй”-н 3-р дэвтрийн ноорог 2 боть, “Монгол хэлний о, ө, у, ү эгшиг үсгийн тухай”, “-на язгуурын учир, нийлмэл үгийн хам бичих зүй”, “Олон улсын нэр томъёог гадаад үгээс монгол хэлний зүйгээр нийцүүлэн зөв бичих журам” зэрэг хэлний шинжлэлийн бүтээлүүд байна.

“Эрдэм шинжилгээний бүтээл” хэсэгт эрдэм шинжилгээний ач холбогдолтой судалгаа шинжилгээ, зохиол бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, тэмдэглэл зэрэг, “Шүүмж санал, илтгэл” хэсэгт эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөнд хэлсэн үг болон гадаад, дотоодын эрдмийн зэрэг горилогчдын бүтээлд өгсөн санал, шүүмж, илтгэл зэрэг байна.

“Экспедицийн тэмдэглэл” хэсэгт хөдөө орон нутгаар явж байхдаа тэмдэглэж авсан ардын аман зохиол, нутгийн иргэдийн хууч яриа, ерөөл магтаал зэргийг тухайн аймаг сумын нэр, ач холбогдлоор нь хадгаламжийн нэгж бүрдүүлэн хадгалжээ.


“Өдрийн тэмдэглэл” хэсэгт гадаад хэл суралцаж байхдаа тэмдэглэж байсан тэмдэглэлийн дэвтрүүдийг ямар ямар хэл үзэж байхдаа тэмдэглэсэнээр нь төрөл болгож бүрдүүлсэн байна.

“Захидал харилцаа” хэсэгт Б.Ринчений өөрөө гараар болон машинаар цохон гадаад, дотоодын иргэдтэй харьцан илгээсэн, гадаад дотоодын иргэд судлаачдаас ирүүлсэн захидал гэж 2 төрөл болгон ангилж, “Цуглуулгын баримт” хэсгийг хөмрөг үүсгэгчийн цуглуулсан сонин сэтгүүлийн хайчилбараар бүрдүүлжээ.

Бямбын Ринчений захидлуудын тухай

Академич Б.Ринчений захидлын өвөөс эрдэмтэн, судлаач Ж.Цолоо, Б.Катуу, Ж.Сумьяа, Л.Туяа, Ц.Цэрэн, Э.Пүрэвжав, Ч.Энхдалай, О.Шинэбаяр нар сурвалжлан олж, судлан нийтлүүлсэн нь орчин үеийн “Ринчен судлал”-д чухал эх хэрэглэгдэхүүний нэг болсон байна.

Монголчуудын захидал бичгийн түүхэн өв уламжлалаас үзвэл, цаг төр үймээн самуунтай үед элдэв нууцыг ихэд чандлан хамгаалах үүднээс аман захиаг бичмэл захидлаас илүүд үздэг байж. Үүнийг “дуу бариулах ёсон” хэмээн тусгай үг хэллэгээр оноон нэрлэж ирсэн түүхтэй. Эртний монголчуудын дунд элч зарлагын мэдээ, захиаг толгой холбон, ёгт битүү утгатай үг хэллэгээр шүлэглэн өгүүлдэг уламжлалтай “дуу бариулах”, “хэл хүргүүлэх ёс” нь монгол түмний нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц нэгэн ёс уламжлал юм. Энэ тухай эрдэмтэн-зохиолч Б.Ринчен “хэлэх үг элчийн аманд бий”³ хэмээн түүх, уран сайхны онцлогийг илэрхийлэн бичиж үлдээсэн нь бий.



Зураг 2. Б.Ринченд бичсэн байлдагч Л.Баасанхүүгийн захидал

Дээр дурдсан “Бямбын Ринчений хувийн хөмрөг”-т байгаа захидал нь “Б.Ринченээс гадаад, дотоодын хүмүүст илгээсэн захидал” (1948.10.22-1977.01.28), “Б.Ринченд гадаад, дотоодын хүмүүсээс илгээсэн захидал, цахилгаан” (1921-1977) гэсэн товьёгтой хадгалагдаж

³ Б.Ринчен “Нууцыг задруулсан захиа” туурь // Монгол уран зохиолын дээжис. 13-р боть. УБ., 2005.

байна. Эдгээрээс Монгол орны өнцөг булан бүхнээс, дөрвөн зүг найман зовхисоос тухайлбал сурагч, албан хаагч, оёдолчин, инженер, малчин, хорих ангийн хүмүүжигч, цэргийн байлдагч, эрдэмтэн судлаачаас ирсэн захидлууд байна. Харилцаж байсан захидлуудын агуулгыг тоймловол:

- Монгол хэл бичиг
- Түүх, угсаатны зүй
- Дэлхийн олон улсын хэл бичиг судлал
- Эртний судлал
- Аман зохиолын төрөл зүйл
- Бичгийн уран зохиолын мэдээ
- Судар номын мэдээ
- Эрдэм судлалын бүтээлийн тухай
- Талархал
- Зохиолчийн уран бүтээлийн тухай санал, шүүмжлэл
- Эсперанто хэлний тухай
- Ном судар өгөх, мэдээлэх тухай
- Гадаадын уран зохиолын тухай
- Сургууль, мэргэжлээ сонгоход зөвлөгөө хүсэх тухай
- Гэр, сууц хүссэн зэрэг эгэл ардын ахуйгаас эхлээд эрдэм номын үр нөлөө, дэлхийн байдал, монгол судлалын олон асуудлыг хөндсөн байна. Эдгээр олон захидалд их эрдэмтэн үл төвөгшөөн хариу бичиж, зөвлөн сануулж, санал бодлоо солилцон харилцаж байв.

Монгол түмний дунд мөнхөрсөн хэл шинжлэлийн ухааны доктор, профессор, академич Бямбын Ринчений захидал дотроос онцлон нэг аймаг, сумын тэр дундаа Өвөрхангай аймгийн Хужирт сумын сурагчид, багш, орон нутгийн иргэд, эрдэмтэнтэй харилцаж байсан захидлыг дэлгэн үзвэл:

1. Хужирт сумын иргэдийн захидал,
2. Сургуулийн сурагчдын ирүүлсэн үлгэрүүд,
3. Доктор Чой.Лувсанжавын захидал зэрэг болно.

Монгол аман зохиолын өв санг бүрдүүлэх зорилгоор ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн доктор Б.Ринченд Өвөрхангай аймгийн Хужирт сумын V-IX ангийн сурагчид өөрсдийн сонсож мэдсэн үлгэрийг сийрүүлэн бичиж илгээсэн нь Монголын Үндэсний Төв Архивд академич Бямбын Ринчений хувийн хөмрөгийн байнга хадгалагдах баримтын дансанд хадгалагдаж байна. Тус үлгэрийг,

5Б ангийн сурагч Дулам (15 настай)

5Б ангийн сурагч Рэгээдмаа (14 настай)

6А ангийн сурагч Пунсаг (15 настай)

6А ангийн сурагч Дарьдулам (16 настай)

8А ангийн сурагч Д.Пүрэвдорж (17 настай)

9А ангийн сурагч Бямба (18 настай)

9А ангийн сурагч Цэдэнсодном (18 настай)

9А ангийн сурагч Бүдбазар (17 настай) нар⁴ бичиж илгээсэн байна. Үлгэрүүдийг нягталбал монгол ардын аман зохиолын дээж төв халхын үлгэрийн онцлогийг хадгалсан олон сонирхолтой үлгэр бий.

⁴ Үндэсний төв архив. Х №32, Д № 2. Б.Ринчений хувийн хөмрөгийн байнга хадгалагдах баримтын данс. тал 175.



Ангийн ахлагч Э.Вандуй, жолооч Лхасүрэн, Б.Ринчен, Д.Цэрэнсодном нар. 1965 он.

Хужиртын арван жилийн дунд сургуулийн багш Дашид бичсэн захидал⁵

Хужиртын арван жилийн дунд сургуулийн багш Даши танаа.

Улаанбаатар 1963.5.2

Ард түмнийхээ нэрийг нэрлүүлэгтүн!

“Таны бие боловсрол, улсын хэмжээгээр сэхээтний нэг нь, дэлхийн боловсон улсын сэхээтэн эрдэмтэнтэй мөр зэрэгцэж, нэг хоцрогдлын онгорхой нүхийг нь таглаж, манай ардын эзэлбээс зохих суурь судлалын нэгийг нь дэлхийн хэмжээгээр эзэлж чадлаа гэж бодож явах хэрэгтэй. Та бодоод үз, дэлхийн олон улс, шатрын тэмцээн, бөмбөгийн тэмцээн, буудлагын тэмцээн гэх зэрэг тэмцээнд дэлхийн аварга болсон хүн нь улс ардынхаа алдар нэрийг мандуулж, тэр тухай нэгэн зүйлд өөрийнхөө ард түмнийг дэлхийн тэргүүн хэмжээнд хүргэж байгаа юм шүү дээ. Тэгэхэд та шинжлэх ухааны талаар дэлхийн эрдэмтэдтэй мөр зэрэгцэх хэмжээнд хүрч чадвал, тэр тань, ганц таны биеийн амжилт биш, монголын шинжлэх ухааны нэг салбар нь дэлхийн хэмжээнд хүрсний илэрхийлэл юм шүү дээ! - За, эр зориг зорьж, Эх орон, Ард түмнийхээ нэрийг нэрлүүлэх хүн бологтун! Одоо сургаж байгаа сурагч нараа ч Эх орон, Ард түмнийхээ төлөө их юм сурч, эрдэмтэй мэдлэгтэй хүн болох ёстой гэж багаас нь учраа мэдэх, алсыг бодох зоригтон хүмүүс болгон хүмүүжүүлэгтүн.” Ийнхүү Хужирт сумын ирээдүй хүүхэд, багачуудыг сурган хүмүүжүүлэх үйлсэд зориулан шинжлэх ухаан, эрдэм боловсролын үр шимийг хэрхэн хүртэх, түүнийг хэрхэн зааж чиглүүлэх зэргийг зөвлөн захидалдаа өгүүлсэн байна.

“Хүү Сумияад” хэмээх захидал

“Хүү Сумияад” захидлыг 1964 оны 1-р сарын 2-нд буюу шинэ он гарч байх мөчид бичжээ. Хужирт сумын 10 жилийн 10-р ангийн сурагч Сумияа их эрдэмтнээс хэрхэн мэргэжлээ сонгох, цаашид хэрхэх тухай зөвлөн асуусны хариуд их эрдэмтэн түүнд бичсэн хариу захидалдаа:

1. Гадаад хэл сурах
2. Дэлхийн хэлээр шинжлэх ухааны мэдлэгийг хүртэх

⁵ “Монголын залуучууд” 1990. № 77

3. Дөрвөн шинжилгээний хэлийг судлахын чухлыг дэлгэрэнгүй жишээлэн тайлбарлаж бичжээ.

Энэ захидлын эзэн “Сумияа хүү” бол эдүгээ Монгол улсын нэрт геологичдын нэг, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, олон түмэндээ “Давсны” хэмээн алдаршсан Ж.Сумьяа юм. Тэрээр Б.Ринчений зөвлөгөөг даган “Хэл ус мэдлэгийн хувиар газар зүйн шинжлэх ухааны талаар сонирхон олон ном, зохиол судалж, тэр үеэс өөрийгөө бэлдэх хэрэгтэй юм байна гэж бодож эхэлсэн гэдэг. Ингээд геологич болбол өөрийгөө яаж бэлдсэн байх ёстой юм гэдэг чухал асуудалд ямар нэгэн юмнаас айж эмээхгүй шамдан орсон нь энэ салбарт давсны судалгаанаас эхлээд олон эрэл хайгуул, үр бүтээлтэй ажлын суурийг тавьж, 25 жил “Давс”-ны ангийг удирдаж, ангийн дарга, ерөнхий геологич хийсэн хүн энэ салбарт Ж.Сумьяагаас өөр байхгүй ажээ. 1945 онд Америкийн нэгэн мужид содны том ордыг дэлхийд анх удаагаа нээсэн бол Монголд 1942 онд бас нэгэн геологич нээсэн нь Увс аймгийн Буултын нуурт судалгаа хийсэн Ж.Сумьяа юм. Тэндээс доод тал нь хоёр метр зузаан содны эрдэс нээсэн бөгөөд содны эрдэс нь байгальд ховор байдаг”⁶ ажээ.

Хужирт сумын цахилгаан холбооны ажилтан О.Бүүвэйн захидал⁷

Эрдэмтэн, зохиолч Л.Түдэв нэгэнтээ “Захидал бол жаргах цагт сэтгэлийн жигүүр, баярын идээ, зовох цагт итгэлийн жолоо, тайтгарлын эм тан” болдог далдын увдистай билээ. Захидал нь он удаан жил хадгалагдах тусмаа үнэд ордог шижир алт лугаа үнэтэй эрдэнэ болно” хэмээн онцлон бичиж байсанчлан Хужирт сумын цахилгаан холбооны ажилтан О.Бүүвэйн, их эрдэмтний эрдэм ухааныг хүндэтгэн, харилцан захидал солилцож монгол хэл бичиг, эсперанто хэл, дэлхийн олон улсын хэл бичиг, түүх, угсаатны зүй, эртний судлал зэрэг өргөн сэдвийн хүрээнд багш шавийн барилдлага дор суралцан, харилцаж байсан хэд хэдэн захидал мөн Монголын Үндэсний төв архивын хөмрөгт хадгалагдаж байна.

О.Бүүвэй гуай бол монгол хэл бичиг, түүх, угсаатны зүйн өргөн мэдлэгийг олж, үндэстний ухамсар өв соёлоо дээдлэн хүндэтгэж, үр хойчдоо захин сургамжилж ирсэн тэрээр бие даан эсперанто хэлэнд суралцсан эрдэм оюун, бичиг соёлоо өвлөн тээгч хүн байв. Өнөөдөр Бүүвэйн үр хүүхдүүд, төрөл төрөгсөд Монгол улсын зам харилцаа, аж үйлдвэрийн салбарт амжилт дүүрэн хөдөлмөрлөж байна.

Их эрдэмтний шавь доктор, профессор Чой.Лувсанжавын захидал

Бямбын Ринчен Өвөрхангай аймгийн Хужирт суманд ирсэн тухай дунд сургуулийн захирал Чой.Лувсанжавын дурсамжид их л дотно өгүүлсэн нь бий.

Эрдэмтэн Чой.Лувсанжав 1953-1954 онд Хужирт сумын сургуульд багш, захирлаар ажиллаж, 1966 онд “Монгол хэлний өвөрмөц хэллэг” сэдвээр Унгар улсын ШУА-д дэд эрдэмтний зэрэг, 1972 онд “Англи-монгол хэлний харьцуулсан хэлзүй” сэдвээр ЗХУ-д докторын зэрэг хамгаалжээ.

Багш Б.Ринченд бичсэн Чой.Лувсанжавын захидал Монголын Үндэсний Төв Архивын хөмрөгт хадгалагдаж байна. Тэр бээр 1972 онд ЗХУ-д* (хуучнаар) эрдмийн зэрэг



Доктор, профессор Чой.Лувсанжав (1930-1988)

⁶ “Зууны мэдээ” сонин. 2017.11.14

⁷ Үндэсний төв архив. Х №32, Д №2, Б.Ринчений хувийн хөмрөгийн байнга хадгалагдах баримтын данс. тал 58-59.

хамгаалахдаа горилох сэдэв, удирдагч багшийн тухай зөвлөн бичжээ. Уг захидлыг доор сийрүүлэе⁸.

“1971 оны 2 дугаар сарын 8-ны өдөр.

Чой.Лувсанжав ёслон өргөв.

Эрхэм хүндэт доктор багшийн амгаланг айлтгахын ялдар сонордуулах минь багш таныг эндээс морилсны маргаадар, миний сэдвийг багахан өөрчилж англи монгол хэлний үгийн бүтцийг бүтэц зүйн үүднээс, хэлбэр судлалын бүтцийг судлах болгосон болой. Миний багш болж буй тэрхүү Ярцева⁹ хэмээх эрдэмтэн бүтэц зүйн сургуультай хүн байна. Энэ сэдвийн талаар багш та алтан сургаалаа хайрламуй. Энэ тухай нэлээд хэдэн асуулт бичиж явуулсныг манай тэнхимийн багш нарын нэг нь танд бараалхаж асуух тул дэлгэрэнгүй хариу айлдмуй хэмээн эрин гуйя. Миний эл захидлыг танд барьж буй хүмүүн болбоос холбооны мэргэжлийн англи хэлтэй хүн. Миний хамт холбооны нэр томьёо гурван хэлээр зохиолцсон хүн. Таны хөвгүүн Барсболд бид нэг буудалд сууж байгаа болой.

Багш та шуудангаас нөгөө эртний үлгэрийнхээ номыг авсан уу?

Үүний тулд хичээнгүйлэн ёсолсон мөхөс шавь Чой.Лувсанжав.

Оросын нийслэл хотноо”¹⁰ гэж бичжээ.

Зураг 4. Монгол улсын хэл шинжлэлийн нэрт эрдэмтэн, доктор профессор
Монгол улсын гавьяат багш Чой.Лувсанжав


Мөн захидлын ар талд монгол бичгээр “миний сэдэв” гээд англи хэлээр “*Contrastive Analysis of the Morphological Structure of Words in Mongolian and English. (in the light of Structuralism)*” гэж сэдвээ бичжээ.

Энэ дашрамд нэгэн баримтыг дурдвал, Чой.Лувсанжав багшийг эрдмийн зэрэг хамгаалах үед профессор Т.А.Бертегаев “Өнөөдөр Лувсанжав докторын зэрэг хамгаална. Лувсанжавын эх хэл нь монгол, унаган хэл нь хятад, эрдмийн зэргээ англи хэлээр хамгаална. Та бүхэн түүнтэй дорнын 5, өрнийн 8 хэлээр ном хаялцаж болно” гэж их эрдэмтний тухай үнэлэн өгүүлж байсан түүхтэй. Эрдэмтэн Чой.Лувсанжав бол академич Б.Ринчен багшийнхаа эрдэм ухааныг өвлөн үргэлжлүүлсэн бичгийн их хүмүүн билээ.

⁸ Шаргал өнгийн цаасан дээр мөр тэтгэн монгол бичгээр бичсэн захидлын 7 үгийг Б.Ринчен улаан өнгөөр засварлан бичжээ.

⁹ Доктор, профессор Виктория Николаевна Ярцева (1906-1999) Санкт-Петербург хотод төрж, 1933 онд Ленинградын Улсын багшийн дээд сургуулийг төгсжээ. 1940 онд “Англи хэлний хөгжил” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. ЗХУ-ын (хуучнаар) Ленинградын Улсын Багшийн Их Сургууль, Ленинградын Улсын Их Сургууль, Уралын Улсын Их Сургууль, Москвагийн Улсын Багшийн Гадаад Хэлний Дээд Сургуульд багш, Англи хэлний факультетын декан, 1944-1952 онд Ленинградын Улсын Их Сургуулийн профессор байсан бөгөөд 1948 оноос Англи хэлний тэнхимийг, 1950-аад оноос Москвагийн Улсын Их Сургуулийн Герман хэлний тэнхимийг тус тус удирдаж, 1950-1964 онд ЗХУ-ын ШУА-ийн Шинжлэх ухааны боловсон хүчнийг бэлтгэх тэнхимд, 1954 оноос Оросын Хэл шинжлэлийн хүрээлэнд ажиллаж, 1988 он хүртэл Герман хэлний салбарыг удирдаж, 1964 онд тус хүрээлэнгийн дэд захирал, 1968-1977 онд захирлаар ажиллажээ.

¹⁰ Үндэсний төв архив. Х №32, Д № 2, Б.Ринчений хувийн хөмрөгийн байнга хадгалагдах баримтын данс. тал 73.



Зураг 5. Б.Ринченд бичсэн шавь Чой-Лувсанжавын захидал

Академич Б.Ринчен “Захидал харилцааны боловсрол чухал болж байна”¹¹ хэмээн нэгэнтээ өгүүлж, захидал бол хүн төрөлхтний эгэл жирийн харилцааны ердийн хэрэглүүр төдийгүй, хувь хүний сэтгэлийн толь юм гэж үзэж байсныг түүний олон хүнтэй харилцаж байсан захидлуудаас жишээлэн үзүүлсэн дээрх хэдхэн захидал, баримт бүрэн гэрчилж чадна.

Академич Бямбын Ринчен бээр эрдэм мэдлэгийг дээдлэгч, өв соёлоо эрхэмлэгч, оюун билигт түмний төлөөлөл жирийн малчин, ажилчин, цэрэг эрс, дунд сургуулийн сурагчаас эхлээд нэр алдар нь дэлхий даяар цуурайтсан монголч эрдэмтэд, улс төрийн зүтгэлтэн зэрэг олон түмэнтэй захидлаар харилцаж, монгол хэл бичиг, түүх, соёл, угсаатны зүй, дэлхийн олон улсын хэл бичиг судлал, эртний аман ба бичгийн зохиол, ном судар, эрдэм судлалын бүтээл, зохиолчийн уран бүтээлийн тухай санал, шүүмжлэл, зөвлөгөөг солилцон, монгол түмнийхээ оюун билгийн өв санг хүндэтгэн соёрхож, харилцаж байсныг түүний захидлын түүх тод өгүүлнэ.

¹¹ 1968 оны XII сарын 12-ны “Хөдөлмөр” сонин, № 149